

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН”

АУДИТЫН КОД: ГСА-2022/31-2-ШТА-ГА

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор:
Б.Сарантуяа, Утас: 70543156
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр,
Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дарханбат, Утас: 70543179
Цахим хаяг: darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер
Г.Наранбаяр

Ахлах аудитор
Б.Дарханбат

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70543156, 70543179
дугаарын утсаар харилцана
уу.

ХАЯГ:

Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 205 тоот

2022 оны 10 дугаар сар

АГУУЛГА

АГУУЛГА 2

ТОВЧИЛСОН ҮГС 3

Бодлогын баримт бичгийн төлөвлөлтийг бодитой хийхгүй байгаа нь хэрэгжилт, үр дүнд сөргөөр нөлөөлж байна. 8

1.1 Дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг бодитой төлөвлөөгүй байна. 8

1.2 Үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна. 9

Санхүүгийн эх үүсвэрийг тооцоо судалгаа, шинжилгээнд үндэслэн төлөвлөхгүй байгаагаас хөтөлбөр, арга хэмжээ зорилтот түвшиндээ хүрч үр дүнтэй хэрэгжээгүй байна. 11

2.1 Төсвийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлж бодлого зохицуулалт, хөрөнгө оруулалтын шинжтэй арга хэмжээг түлхүү хэрэгжүүлэх шаардлагатай байна. 11

Хог хаягдлын менежментийг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн орчин бүрдээгүй байна. 13

3.1. Хог хаягдлын менежментийг сайжруулах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, гүйцэтгэлийг зохион байгуулах, хяналт тавихад оролцогч талуудын чиг үүрэг тодорхой боловч, уялдаатай ажиллаж чадаагүй байна. 13

3.2. Хог хаягдлын менежментийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй байна. 15

Дүгнэлт

Зөвлөмж

Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Тайлан баталгаажуулах тушаал

Тайлангийн хавсралтууд

ТОВЧИЛСОН ҮГС

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
БББ	Бодлогын баримт бичиг
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГСА	Говьсүмбэр аймаг
ДАХШҮХ	Дотоод аудит хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
ЗДҮАХХАХТ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ҮАХ	Үйл ажиллагааны хөтөлбөр
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШҮ	Хяналт шинжилгээ үнэлгээ
ШГС	Шивээговь сум
ЭЗНХҮЧ	Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх:

Аудитыг УИХ-ын төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, МУЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Хог хаягдлын менежментийн хэрэгжилт үр дүнг үнэлж, аудитын дүн дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын дагуу аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Хог хаягдлын менежментийн талаар “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж байна уу?
- Хог хаягдлын менежментийг сайжруулахад шаардлагатай хөрөнгийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан уу?
- Хог хаягдлын менежментийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн үү?

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- ✓ Хог хаягдлын тухай хууль
- ✓ Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- ✓ Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-МУИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол
- ✓ “Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ЗГ-ын 2014 оны 298 дугаар тогтоол
- ✓ “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам”- БОАЖС-ын 2018 оны А/428 дугаар тушаал
- ✓ Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл
- ✓ Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө
- ✓ Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 2016-2020 он, 2020-2024 он
- ✓ Холбогдох бусад хууль тогтоомж, хөтөлбөр, гэрээ, эрх зүйн актууд
- ✓ Аймаг, сумын ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, холбогдох шаардлагатай хууль, дүрэм, журам

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчны тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Үндэсний болон дэд хөтөлбөр, аймгийн ИТХ, Засаг даргын шийдвэр, бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд 2020-2021 онд хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, аймаг, сумын Засаг даргын тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ болон холбогдох бусад байгууллагыг хамруулаа.

Аудитын арга зүй:

Гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж УДИР 3910, УДИР 3920, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “ТАБ-аас аудит хийх журам”, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/81 дүгээр тушаал, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан гүйцэтгэлээ.

Аудитаар аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичиг, Үндэсний болон дэд хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт, оролцогч байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, бодлого, шийдвэр, төсөв санхүүгийн төлөвлөлт, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулаа.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын талбарын ажлыг 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлүүлж, тайланг Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан шалгагдагч байгууллага болон холбогдох эрх бүхий албан тушаалтанд 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр хүргүүлээ.

Хүндрэл бэрхшээл:

Аудитыг гүйцэтгэх хугацаанд “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудиттай аудитын хугацаа давхардсан, 2 орон тоо дутуу ажиллаж байгаагаас аудитын багт хүний нөөцийн дутагдал үүссэн, мөн сумдын мэргэжилтнүүд солигдсон зэргээс шалтгаалан аудитад шаардлагатай баримт материалуудыг бүрэн ирүүлээгүй нь аудитад хүндрэл учруулж байлаа.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

“Алсын хараа 2050” дунд хугацааны бодлогын баримт бичгийн “2-Хүнд ээлтэй амьдрах орчин”, “6-Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил”, “9- Орчин төвтэй шийдэл” зэрэг 3 зорилтод 28 арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бол аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд 5 арга хэмжээг 11.7 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Аймгийн Засаг даргын 2016-2020, 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 7 арга хэмжээг 930.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд 32.2 га талбайд хог хаягдлын 3 төвлөрсөн цэг бүртгэлтэй бөгөөд жилд дунджаар 16.0 мянга орчим тн хог хаягдлыг хүлээн авч булшилж байна. Үүнээс 3.4 мянган тн буюу 21% нь барилгын, 6.8 мянган тн буюу 41% нь цаас болон хуванцар хог хаягдал эзэлж байна. Мөн эрүүл мэндийн байгууллагууд жилд дунджаар 22.8 тн аюултай хог хаягдлыг гаргаж байна.

2018 онд Улсын хэмжээнд хийсэн эвдэрсэн газрын тооллогоор 1726 га газар түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолт, авто замын ажил, уул уурхайн олборлолт, цэргийн ангийн барилгын туурь, хүний буруутай үйл ажиллагааны улмаас эвдэрсэн байна.

Хог хаягдлын хураамжийн үйлчилгээний орлогод 2020 онд 102.8 сая төгрөг төлөвлөж 114.8 саяыг төвлөрүүлсэн. 2021 онд 119.0 сая төгрөг төлөвлөж 143.9 саяыг төвлөрүүлж жил бүр 11.9-24.9 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Аймгийн төв буюу Сүмбэр суманд “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагааг эрхэлдэг бол Баянтал, Шивээговь сумдад энэ чиглэлээр үйл ажиллагааг явуулдаг ААНБ байхгүй байна.

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Дахивар авах цэг	15

Дүрслэл товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Аймгийн ЗДҮАХ-т тусгасан хог хаягдлыг бууруулах арга хэмжээ	9
Дүрслэл 2	АЗДҮАХ-ийн хүрээнд төсвөөс зарцуулсан хөрөнгийн зориулалт	11-12
Дүрслэл 3	2020-2021 онд хог хаягдлыг бууруулахтай холбоотой арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн зориулалт	12
Дүрслэл 4	Төрийн байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоо	14
Дүрслэл 5	Төрийн байгууллагуудын хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ	15
Дүрслэл 6	Сумдад мөрдөж буй хог хаягдалтай холбоотой шийдвэрүүд	16

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн ЗДТГ-ын ДАХШҮХ-сээс дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн	9
Хүснэгт 2	Дэд хөтөлбөр (арга хэмжээ)-т тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан төсөв	10
Хүснэгт 3	БОАЖГ-аас гаргасан үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилт	10
Хүснэгт 4	АЗДТГ-ын ДАХШҮХ-ийн хяналт-шинжилгээний дүн	10
Хүснэгт 5	Дунд болон богино хугацааны баримт бичигт тусгасан арга хэмжээний хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт	11
Хүснэгт 6	Аймаг, сумдын ОНХС-гийн хог хаягдлын менежменттэй холбоотой арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэл	13
Хүснэгт 7	Хог хаягдлын чиглэлээр 2014-2021 онд Тохижилт сүмбэр ОНӨААТҮГ-д хийсэн хөрөнгө оруулалтын ажил	16
Хүснэгт 8	Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ нь 2020,2021 оны орон тоо цалингийн сан	17

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Аймаг сумын ИТХ, Засаг даргаас Хог хаягдлын тухай хуулиар олгогдсон эрхийн хүрээн баталж мөрдүүлэх эрхзүйн актын жагсаалт	23
Хавсралт 2		

БҮЛЭГ 1

Бодлогын баримт бичгийн төлөвлөлтийг бодитой хийхгүй байгаа нь хэрэгжилт, үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

1.1 Дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг бодитой төлөвлөөгүй байна.

1.1.1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд эх үүсвэрийг 2016-2020 онд 810.0 сая, 2021-2024 онд 120.0 сая төгрөгөөр төлөвлөсөн нь өмнөх хөтөлбөрөөс 690.0 сая төгрөг буюу 6.75 дахин буурсан байна.

Энэ нь 2016-2020 оны ЗДҮАХХАХТ-д 150.0 сая төгрөгөөр “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-т хогны машин, 250.0 сая төгрөгийн авто пүү, 80.0 сая төгрөгөөр барилгын болон туурь хог хаягдал цэвэрлэх, 110.0 сая төгрөгөөр аймгийн төвд ландфилл технологийг сайжруулах арга хэмжээг төлөвлөснөөс шалтгаалжээ.

Дунд хугацааны бодлогын баримт бичигт зарим эх үүсвэрийг үнэн зөв тооцож, зорилт арга хэмжээтэй уялдуулж төлөвлөөгүй байна. Тухайлбал:

- 2016-2020 оны ЗДҮАХХАХТ-ний 12.46-т “Аймаг сумдын төвлөрсөн хогийн цэгийг хашаажуулж, ландфилл технологийг үе шаттайгаар сайжруулна” гэсэн арга хэмжээг төлөвлөж, хүрэх түвшин, үр дүнгийн шалгуур үзүүлэлтээр “Сүмбэр суманд авто пүү байршуулна” гэж 250.0 сая төгрөгийг тооцоо судалгаанд үндэслэхгүйгээр төлөвлөсөн.
- 2021-2024 оны ЗДҮАХХАХТ-ний 5.1.12-т “Аймаг, сумдын төвийн хог хаягдлын менежментийг сайжруулан, ахуйн болон туурь хог хаягдал бүхий талбайг үе шаттайгаар бууруулж, аймгийн төвд ландфилл технологийг сайжруулна” гэсэн арга хэмжээг төлөвлөсөн боловч эх үүсвэрийг төлөвлөөгүй.

Эдгээр нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1¹, 18 дугаар зүйлийн 18.1², Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1³-т тус тус зөрчсөн бөгөөд бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээ зорилтот түвшинд хүрч хэрэгжихгүй байх үр нөлөөтэй байна.

Бодлогын баримт бичигт тусгаж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг бодитой төлөвлөх зөвлөмжийг аймаг, сумдын Засаг дарга нарт өгөхөөр шийдвэрлэв.

1.1.2 Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хог хаягдлын менежментийн талаар 7 арга хэмжээ, аймаг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд 5 арга хэмжээг төлөвлөж, жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлсэн байна.

Дүрслэл №1

2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Сумдын хог хаягдлын менежментийг сайжруулна.

Аймаг, сумдын төвлөрсөн хогийн цэгийг үйл ажиллагаа сайжирч, орчны бохирдлоос сэргийлнэ.

Хуримтлагдсан хур хог хаягдал, туурь балгасыг цэвэрлэж нөхөн сэргээнэ.

2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Аймаг, сумдын төвийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн, аймгийн төвийн хог хаягдлыг ландфилл технологийн дагуу буулшина.

Туурь хог хаягдал бүхий талбайг үе шаттайгаар цэвэрлэнэ.

Агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж, агаарын чанарын хяналтыг сайжруулна.

Нутгийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагуудыг авто тээврийн хэрэгслээр хангана.

(Эх сурвалж: Аймгийн ИТХ-аар батлагдсан Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө)

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл нь “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичигтэй нийцэж байгаа бөгөөд хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй байна.

¹ 15.1.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь бүсчилсэн хөгжлийн бодлого, аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилттой уялдсан байх ба тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн дунд хугацааны эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын чиглэл, түүнд хүрэх зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, төсөв, санхүүгийн эх үүсвэр, шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна.

² 18.1.Дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигт төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байна.

³ 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл /жилийн хөгжлийн төлөвлөгөө/-ийн хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын ДАХШҮХ-ээс Засгийн газрын 2017 оны 89, 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журамд заасан хугацаанд дүгнэн, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, үнэлгээг баталгаажуулсан байна.

1.1.3 Аймгийн ЗДТГ-ын ДАХШҮХ-сээс дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг 88-92.5%-иар үнэлсэн байна. Үүнээс хог хаягдлын менежментийг сайжруулахтай холбоотой зорилт, арга хэмжээг 2021 онд 89.3%, 2020 онд 100% хэрэгжсэн гэж үнэлсэн байна.

Хүснэгт №1

Он	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	Аймгийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл /жилийн хөгжлийн төлөвлөгөө/
2021	88.8% (2021 оны жилийн эцсийн байдлаар)	92.5% (2021 оны жилийн эцсийн байдлаар)
2020	91.7% (2016-2020 4 жилийн байдлаар)	88.0% (2020 оны жилийн эцсийн байдлаар)

(Эх сурвалж: аймгийн ЗДТГ-ын ДАХШҮХ-н тайлан)

Бодлогын баримт бичгийн хог хаягдалтай холбоотой арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээгээр шалгуур үзүүлэлтийг хангаагүй арга хэмжээг бүрэн хэрэгжсэнээр тайлагнасан байна. Үүнд: Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт /ЗДҮАХХАХТ-ний 12.46/- аймаг сумдын ландфилл технологийг сайжруулах талаар хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй. Арга хэмжээний шалгуур үзүүлэлтээ “Шивээговь сумын төвлөрсөн хогийн цэгийг шинээр төлөвлөн байгуулна”, “Сүмбэр суманд авто пүү байршуулна” гэж тодорхойлсон боловч эдгээр ажлууд хийгдээгүй, шалгуур үзүүлэлтдээ хүрээгүй байхад 100% хэрэгжсэн гэж үнэлжээ.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 89 тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 5 дугаар зүйлийн 5.2.3, 6.2.1.1-т заасныг тус тус зөрчсөн бөгөөд арга хэмжээний хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй, заавар аргачлалын дагуу үнэлгээ хийхгүй байгаагаас шалтгаалсан байна.

1.1.4 Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл (жилийн хөгжлийн төлөвлөгөө)-д хийсэн хяналт шинжилгээ үнэлгээгээр хог хаягдлын менежменттэй холбоотой арга хэмжээг хангалттай хэрэгжсэн гэж дүгнэсэн тул цаашид сайжруулах чиглэлээр үүрэг даалгавар өгөөгүй байна.

1.2 Үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.

1.2.1 Хог хаягдлын менежментийг сайжруулах болон Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв батлаагүй байна.

Харин 2020 оны “Агаар орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр”-ийн болон 2021 оны “Агаар орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ”-ний төсвийг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, БОАЖГ-аас бэлтгэн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, аймгийн ИТХ-аар батлуулсан байна. Аймгийн ОНХС-гаас “Агаар орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр”-т 2020 онд 10.0 сая, 2021 онд Агаар орчны бохирдлыг бууруулах арга хэмжээнд 13.5 сая, сумдын ОНХС-д 38.1 сая, нийт 61.6 сая төгрөгийн эх үүсвэр батлагджээ.

Дэд хөтөлбөр болон арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг, сумдын ОНХС-д батлагдсан төсвийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2

Эх үүсвэр	АОНХС-Агаар орчны бохирдол бууруулах дэд хөтөлбөр	Баянтал ОНХС-Сумын төвийн хог хаягдлыг бууруулах, хог хаягдлын менежментийг сайжруулах зардал	Сүмбэр ОНХС-Байгаль хамгаалах хөтөлбөр-Барилгын болон туурь хог хаягдал цэвэрлэх арга хэмжээ	Шивээговь ОНХС-Сумын байгаль орчин, эрүүл ахуй, орчны бохирдлыг бууруулах Хоггүй сум дэд хөтөлбөр	Нийт
2021	13.5	3.0	7.0	5.0	28.5
2020	10.0	6.3	1.0	15.8	33.1
Дүн	23.5	9.3	8.0	20.8	61.6

Батлагдсан төсөвтэй холбоотой санхүүгийн тооцоолол, төлөвлөлтийн баримт материалыг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ээс аудитын явцад гаргаж ирүүлээгүй.

1.2.2 Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2⁴, 9.3.4⁵-т заасны дагуу орон нутагт хэрэгжих хөтөлбөрийг баталж, биелэлтэд хяналт тавих эрхийг аймгийн ИТХ, Засаг даргад

⁴ 9.1.2 “Хог хаягдлын менежментийг сайжруулах орон нутгийн хөтөлбөрийг баталж, биелэлтэд хяналт тавих”

⁵ 9.3.4 “Хог хаягдлын менежментийг сайжруулах орон нутгийн хөтөлбөрийн биелэлтийг хангах”

олгосны дагуу Хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөрийг боловсруулж батлуулаагүй байна. Үүнээс шалтгаалж дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт үндэсний хөтөлбөрийн уялдаа хангагдаагүй байна.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.6-т заасныг тус тус зөрчсөн бөгөөд бодлогын баримт бичгийн уялдаа алдагдах, үндэсний хөтөлбөр орон нутагт бүрэн хэрэгжихгүй байх үр нөлөөтэй байна.

Иймд Хог хаягдлын тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

Үндэсний хөтөлбөрт нийцүүлэн аймгийн хэмжээнд “Хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр”-ийг батлаагүй боловч аймгийн Засаг даргын 2020 оны А/94 дүгээр захирамжаар “Агаар орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр”, 2021 оны А/49 дүгээр захирамжаар “Агаар орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ”-г тус тус баталсан бөгөөд энэхүү дэд хөтөлбөр болон арга хэмжээний хүрээнд “Хог хаягдлын менежментийг сайжруулах арга хэмжээ”-г тусган хэрэгжүүлсэн байна.

1.2.3 Байгаль, орчин, аялал жуулчлалын газраас “Хог хаягдлын менежментийг сайжруулах”, “Агаар орчны бохирдлыг бууруулах” үндэсний хөтөлбөр, 2020 оны Агаар орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр, 2021 оны арга хэмжээний хэрэгжилтийг тус тус дүгнэн хууль, журамд заасан хугацаанд аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-д хүргүүлсэн байна. /Хүснэгтээр харуулбал/

Хүснэгт № 3

Он	Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр	Хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр	Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	Агаар орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр
2021	88.4%	Батлагдаагүй.	90.0%	88.0%
2020	81.4%	Батлагдаагүй.	88.4%	75.0%

(Эх сурвалж: БОАЖГ-аас ирүүлсэн бодлогын баримт бичгийн хэрэгжилт)

1.2.4 Аймгийн ЗДТГ-ын ДАХШҮХ-ээс зөвхөн Агаар орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 4

Он	Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр	Хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр	Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	Агаар орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр
2021	Эрх зүйн орчин өөрчлөгдсөн тул хийгээгүй.	Батлагдаагүй.	Эрх зүйн орчин өөрчлөгдсөн тул хийгээгүй.	Дэд хөтөлбөрийг арга хэмжээ болгон хэрэгжүүлсэн боловч ХШҮ хийгээгүй.
2020	ХШҮ хийгээгүй.	Батлагдаагүй.	ХШҮ хийгээгүй.	75.0%

(Эх сурвалж: АЗДТГ-ын ДАХШҮХ, БОАЖГ-ын тайлан)

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй нь Засгийн газрын 2017 оны 89 тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 8 дугаар зүйлийн 8.1⁶-д заасныг зөрчсөн ба үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт бодитой, үнэн зөв тайлагнаагүй байх эрсдэл үүссэн байна.

Аймгийн ЗДТГ-ын ДАХШҮХ-ээс 2021 онд үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй нь 2020 онд шинээр батлагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2021 оны 314 дугаар тогтоолын хавсралтаар Төрөөс баримтлах бодлого-11, стратеги зорилт-4, үндэсний хөтөлбөр-47 нийт 62 бодлогын баримт бичгийг хүчингүй болгосонтой холбоотой байна.

1.2.5 Аймгийн ЗДТГ-ын ДАХШҮХ-ээс 2020 онд аймгийн хэмжээнд хэрэгжиж буй 16 дэд хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд дундаж үнэлгээгээр 86.4%-ийн хэрэгжилтэй гэж дүгнэжээ. Харин “Агаар орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр” 75.0%-тай хэрэгжсэн буюу дунджаас доогуур үнэлэгдсэн байхад дутуу хэрэгжсэн арга хэмжээг сайжруулах үүрэг даалгавар өгөөгүй байна.

⁶ 8.1 Захиргааны байгууллага нь хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, хэрэгжилтийг салбар, чиглэлээр ангилан энэхүү журмын 6 дугаар хавсралтын дагуу гаргаж тайланг журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд харьяалах дээд шатны байгууллагад хүргүүлнэ.

Цаашид бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээг шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүнгийн уялдаатай цогц байдлаар үнэн зөв үнэлэх шаардлагатай байна.

БҮЛЭГ 2

Санхүүгийн эх үүсвэрийг тооцоо судалгаа, шинжилгээнд үндэслэн төлөвлөхгүй байгаагаас хөтөлбөр, арга хэмжээ зорилтот түвшиндээ хүрч үр дүнтэй хэрэгжээгүй байна.

2.1 Төсвийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлж бодлого зохицуулалт, хөрөнгө оруулалтын шинжтэй арга хэмжээг түлхүү хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2.1.1 АЗД-ын 2016-2020, 2021-2024 оны ҮАХ, 2020-2021 оны агаар, орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр, арга хэмжээнд нийт 991.6 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 2021 оны жилийн эцсийн байдлаар 701.0 сая төгрөгийг зарцуулж, хөрөнгийн зарцуулалт 70.7%-тай байна.

Дунд болон богино хугацааны баримт бичигт тусгасан арга хэмжээний хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №: 5		(сая төгрөгөөр)	
Аймгийн ЗДҮАХХАХТөлөвлөгөө		Төлөвлөсөн хөрөнгө	Зарцуулсан хөрөнгө
АЗД-ын 2016-2020 оны ҮАХ хэрэгжүүлэх арга хэмжээ		810.0	462.4
АЗД-ын 2021-2024 оны ҮАХ-г хэрэгжүүлэх арга хэмжээ		120.0	192.2
2020 оны агаар, орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөрийн хүрээнд аймаг, сумдын ОНХС-гаас хэрэгжүүлэх хог хаягдлыг бууруулахтай холбоотой арга хэмжээ		33.1	22.8
2021 онд аймаг, сумдын ОНХС-гаас хэрэгжүүлэх хог хаягдлыг бууруулахтай холбоотой арга хэмжээ		28.5	23.6
Нийт дүн		991.6	701.0

(Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын 2016 оны 4-р хуралдааны 4-р тогтоол, 2020 оны 2-р хуралдааны 5-р тогтоол, аймгийн ЗД-ын 2021 оны А/102 захирамж)

Үүнээс АЗД-ын 2016-2020, 2021-2024 оны ҮАХ-т нийт 930.0 сая төгрөг төлөвлөж, 2021 оны байдлаар 654.6 сая төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 70.4%-тай байна.

АЗДҮАХ-ийн хүрээнд төсвөөс зарцуулсан хөрөнгийн зориулалтыг графикаар харуулбал:
График № 2

(Эх сурвалж: Аймаг, сумдын ЗДҮАХ-н тайлан болон ОНХС, ОНХО-ын санхүүгийн баримт)



Графикаас харахад: Зарцуулалтын 331.7 сая буюу 50.7%-ийг автомашин худалдан авах, 165.9 сая төгрөг буюу 25.3%-ийг хог хаягдал цэвэрлэх, устгах, 137.0 сая буюу 20.9%-ийг хогийн цэг хашаажуулах, хогийн саваар хангахад зарцуулсан байна.

2020-2021 онд аймаг, сумдын ОНХС-гаас хэрэгжүүлэх хог хаягдлыг бууруулахтай холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт 61.6 сая төгрөг төлөвлөж, 46.4 сая төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 75.3%-тай байна.

2020-2021 онд хог хаягдлыг бууруулахтай холбоотой арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн зориулалтыг графикаар харуулбал:

График №3

(сая төгрөгөөр)



(Эх сурвалж: Аймаг, сумдын ОНХС-гийн санхүүгийн баримт)

Графикаас харахад: Зарцуулалтын 23.9 сая буюу 51.5%-ийг барилгын болон туурь хог хаягдал цэвэрлэх, 7.5 сая буюу 16.2%-ийг автомашины хөдөлгүүр худалдан авах, 5.0 сая буюу 10.8%-ийг хогийн цэг хашаажуулах, 5.0 сая буюу 10.8%-ийг судалгаа шинжилгээний ажил хийхэд зарцуулжээ.

Аймаг, сумдын дунд болон богино хугацааны бодлогын баримт бичиг, дэд хөтөлбөрт тусгасан хог хаягдалтай холбоотой зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

2.1.2 Зардлын гүйцэтгэлийг авч үзэхэд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийг санхүүгийн тооцоо, судалгаа шинжилгээнд үндэслэн төлөвлөхгүй байгаагаас шалтгаалж зорилтот түвшиндээ хүрч үр дүнтэй хэрэгжихгүй байна.

Дунд хугацааны бодлогын баримт бичигт буюу 2016-2020 оны Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хог хаягдлыг бууруулах чиглэлээр 810.0 сая төгрөг төлөвлөж, 462.4 сая төгрөг зарцуулж, гүйцэтгэл 57.1%-тай байна. Гүйцэтгэлээр зарцуулсан 462.4 сая төгрөгийн 67.7% нь нэг удаагийн болон урсгал зардлын шинжтэй арга хэмжээг санхүүжүүлсэн бөгөөд хог хаягдлын менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай суурь дэд бүтэц, хөрөнгө оруулалтын шинжтэй арга хэмжээнд зарцуулаагүй байна.

Тухайлбал: Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт хог хаягдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд 2016-2020 онд 35.2 га, 2021 онд 7.2 га нийт 42.4 га талбайн хур хог хаягдлыг цэвэрлэж, хур хог хаягдалтай талбайн хэмжээг 2.5 хувиар бууруулсан. Сумдын төвлөрсөн хогийн цэгт 2020-2021 онд 33.8 мянган тонн хог хаягдлыг цуглуулан тээвэрлэж, үүний 63.3 хувь буюу 21.4 мянган тонныг булшилжээ.

2021-2024 оны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хог хаягдалтай холбоотой 120.0 сая төгрөг төлөвлөж 192.2 сая төгрөгийг зарцуулаад байна. Төлөвлөгдөөгүй эх үүсвэрээс буюу авто замын сангийн 114.4 сая төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэн нь төсөв хэтрэх шалтгаан болжээ.

Уг автомашин нь орон нутгийн онцлогт тохирохгүй технологийн шаардлагыг хангахгүй байгаагаас хог хаягдал цэвэрлэх үйл ажиллагаанд ашиглагдахгүй байна.

Аймгийн хэмжээнд “Хог хаягдлын менежментийг сайжруулах” нэгдсэн төлөвлөгөө батлаагүйгээс аймаг болон сумдын Засаг дарга нар Хог хаягдлын тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хог хаягдлыг бууруулах ажлыг дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигтээ тусган ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн хог хаягдлын менежменттэй холбоотой арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 6

(сая төгрөгөөр)

Он	АОНХС-Агаар орчны бохирдол бууруулах дэд хөтөлбөр		Баянтал сум ОНХС-Сумын төвийн хог хаягдлыг бууруулах, хог хаягдлын менежментийг сайжруулах зардал		Сүмбэр сум ОНХС-Байгаль хамгаалах хөтөлбөр-Барилгын болон туурь хог хаягдал цэвэрлэх арга хэмжээ		Шивээговь сум ОНХС-Сумын байгаль орчин, эрүүл ахуй, орчны бохирдлыг бууруулах Хоггүй сум дэд хөтөлбөр		Нийт	
	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц
2021	13.5	11.6	3.0	0.0	7.0	7.0	5.0	5.0	28.5	23.6
2020	10	2	6.3	6.3	1.0	1.0	15.8	13.5	33.1	22.8

Дүн	23.5	13.6	9.3	6.3	8.0	8.0	20.8	18.5	61.6	46.4
-----	------	------	-----	-----	-----	-----	------	------	------	------

(Эх сурвалж: Аймаг, сумын ОНХС-гийн дэд хөтөлбөрийн санхүүгийн баримт-хог хаягдлын менежменттэй холбоотой арга хэмжээний зардал)

Богино хугацааны бодлогын баримт бичигт буюу аймаг, сумдын Засаг даргын захирамжаар батлагдсан 2020-2021 онд дэд хөтөлбөрийн зорилт, арга хэмжээнд нийт 61.6 сая төгрөгийг төлөвлөж гүйцэтгэлээр 46.4 сая буюу 75.3%-ийг зарцуулсан нь төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байгаатай холбоотой байна. Тухайлбал:

1. 2020 оны “Агаар орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр”-т 10.0 сая төгрөгөөр 4 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 1 арга хэмжээнд 2.0 сая төгрөг буюу санхүүжилтийн 20%-ийг зарцуулсан.

2. 2021 оны Баянтал сумын ОНХС-гаас “Сумын төвийн хог хаягдлын менежментийг сайжруулах” арга хэмжээнд 3.0 сая төгрөг батлагдсан боловч орон нутагт хог хаягдал цуглуулж тээвэрлэх үйлчилгээ эрхлэгч ААНБ, иргэн байхгүйгээс уг арга хэмжээ хэрэгжээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн зүйлийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁷, 14 дүгээр 14.2.3⁸-т заасныг тус тус зөрчсөн бөгөөд төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай байна.

Иймд хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, суурь дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх буюу төвлөрсөн хогийн цэгт цахилгаан татах, авто пүү байршуулах, ландфиллын стандартыг хангах, түүнд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөж батлуулах, хэрэгжилтийг хангах зөвлөмжийг аймаг, сумдын Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

БҮЛЭГ 3

Хог хаягдлын менежментийг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн орчин бүрдээгүй байна.

3.1 Хог хаягдлын менежментийг сайжруулах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, гүйцэтгэлийг зохион байгуулах, хяналт тавихад оролцогч талуудын чиг үүрэг тодорхой боловч, уялдаатай ажиллаж чадаагүй байна.

3.1.1 Хог хаягдлын тухай хуулиар орон нутаг дахь төрийн байгууллагуудын чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна.



(Эх сурвалж: Аудитын явцад хийсэн ажиглалт)

⁷ 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

⁸ 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах

2016-2020 оны Аймгийн ЗДҮАХ-ийн зорилт 2.10 “Хот суурин газрын дэд бүтцийг нэмэгдүүлж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэн, хот тохижилтыг сайжруулна”, 4.2 “Ногоон бүс, ойн зурвас байгуулах, газрын хөрсийг нөхөн сэргээх замаар байгаль орчны доройтлыг сааруулна” зорилтын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд.

Дүрслэл №5

1. Сумдын хог хаягдлын менежментийг сайжруулна.

- * Сумдын ЗДТГ,
- * Тохижилт үйлчилгээний байгууллага,
- * БОАЖГ

2. Аймаг сумдын төвлөрсөн хогийн цэгийг хашаажуулж, ландфилл технологийг үе шаттай сайжруулна.

- * Сумдын ЗДТГ,
- * Тохижилт үйлчилгээний байгууллага,
- * БОАЖГ

3. Хуримтлагдсан хур хог хаягдал, туурь балгасыг цэвэрлэж нөхөн сэргээнэ.

- * Аймаг, сумдын ЗДТГ,
- * Тохижилт үйлчилгээний байгууллага,
- * БОАЖГ

Хуулиар тогтоосон чиг үүргийн хүрээнд аймаг, сумдын Засаг дарга нар хог хаягдлын тухай хуульд заасан дүрэм, журам, бодлогын баримт бичгийг боловсруулж аймаг, сумын ИТХ-аар батлуулаагүй байна.

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ нь 2019, 2020 онд сумын Засаг даргатай гэрээ байгуулаагүй, 2021 онд гэрээ байгуулсан боловч гэрээний хэрэгжилтийг тайлагнаагүй, хог хаягдлын зардлын гүйцэтгэлээр санхүүжүүлэх тогтолцоо бүрдээгүй байна. Энэ нь төрийн байгууллага, албан тушаалтнууд хуульд заагдсан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байгаатай холбоотой байна.

3.1.2 БОАЖГ-аас 2021 онд аймгийн хэмжээнд байгаль орчныг хамгаалах, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах зорилгоор хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэн, ААН-үүдэд ногоон соёлыг төлөвшүүлэх, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах, хандлагаа өөрчлөх “Зөв дадал, эерэг өөрчлөлт, ногоон ирээдүй” нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж иргэн, ААН, төрийн болон төрийн бус байгууллагыг оролцуулан 14 байгууллагын 438 хүнийг хамруулсан байна. Уг арга хэмжээнд 5.2 сая төгрөгийг байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас зарцуулжээ. Мөн хог хаягдлыг ангилан ялгаж дахивар худалдан авах 2 цэгийг нээн бодлогоор дэмжин ажиллаж байгаа нь иргэдийн оролцоог хангасан сайн туршлага болсон байна.

Зураг №1



Зураг №2



2022 оны 04 дүгээр сард Сүмбэр сумын Засаг дарга, “Өнгө нэм” ТББ-тэй байгуулсан хамтран ажиллах гэрээгээр Сүмбэр суманд хог хаягдлын тогтвортой хөгжлийн менежментийг бий болгох зөвлөх үйлчилгээний 10.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан нь хог хаягдлын чиглэлээр мэргэжлийн холбоотой хамтран ажиллах сайн туршлага болж байна.

Баянтал суманд “Хог хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөгөө” боловсруулан иргэд, олон нийтийн санал санаачилгыг тусгах зорилгоор нийт иргэд, ААНБ-уудын дунд 2

удаагийн хэлэлцүүлгийг 2021 онд зохион байгуулсан боловч төлөвлөгөөг эцэслэн батлаагүй байна.

Шивээговь суманд нийтийн эзэмшлийн гудамж талбайг цэвэрлэх гэрээт ажилтан ажиллуулсан нь сумын төвд хог хаягдал бууруулахад иргэдийг татан оролцуулж буй сайн туршлага болсон байна. Мөн сумын Засаг дарга суманд үйл ажиллагаа явуулж буй “Страто”ХХК, МАК” ХХК-иудтай хамтран ажиллаж, нийгмийн хариуцлагын хүрээнд Шивээговь сумын төвд хог хаягдал ангилан ялгах хашаа, шахагч машин, чингэлэг зэргийг тус компаниуд өөрсдийн хөрөнгөөр хийсэн байна.

3.2 Хог хаягдлын менежментийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй байна.

3.2.1 2017 онд шинэчлэн баталсан Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд сумдын ИТХ нь энгийн хог хаягдалтай холбоотой зардлын нэгж тарифыг тооцох аргачлалын дагуу тухайн орон нутагт мөрдөх энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ, цуглуулж тээвэрлэх зардлын нэгж тарифыг батлах эрх зүйн зохицуулалттай байна.

Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 дугаар тушаалын хавсралтаар “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлал”, “Энгийн хог хаягдлыг тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцох аргачлал”-ыг баталсан боловч бодит байдал дээр уг шийдвэр хэрэгжихгүй байна.

Сумдад мөрдөж буй хог хаягдалтай холбоотой шийдвэрүүдийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 6	
Баянтал сум	• Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан тарифын дагуу ногдуулан хурааж байгаа нь хууль эрхзүйн хувьд үндэслэлгүй байна. • Сумын Засаг даргаас 2019 онд хог хаягдлын хураамжийн хэмжээг шинэчлэн батлуулахаар сумын ИТХ-аар хэлэлцүүлсэн боловч одоог хүртэл батлаагүй
Шивээговь сум	• Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 88 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан боловч хүчингүй болсон хуулийн заалтыг үндэслэсэн, • Хураамжийн хэмжээг заавар аргачлалын дагуу тооцоогүй, 2014 онд мөрдөж байсан үнэ тарифыг хэвээр нь баталсан
Сүмбэр сум	• Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 07, ИТХ-ын 2022 оны 07 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолоор тус тус шинэчлэн баталсан. • 2022 онд хураамжийн хэмжээг заавар аргачлалын дагуу тооцолгүй, 2018 оны хураамжийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж тогтоосон нь үндэслэлгүй байна

Хог хаягдлын үйлчилгээний хураамж болон зардлын нэгж тарифыг заавар аргачлалын дагуу бодитой тогтоогоогүйгээс хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжтой ажил үйлчилгээг төрийн захиргааны байгууллага нь өөрөө гүйцэтгэж ирсэн байна.

Статистикийн нэгдсэн мэдээллийн сангаас авсан мэдээгээр дундаж цалин хөлсний хэмжээ 2014 онд 796.6 мянга, 2021 онд 1,279.4 мянга болж 1.6 дахин нэмэгдсэн байхад хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээнд 8 жилийн хугацаанд өөрчлөлт ороогүй байна.

Хог хаягдлын тухай хуульд заасны дагуу аймаг, сумдын ИТХ, Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн хэмжээнд баталбал зохих 9 эрх зүйн баримт бичгээс 4-ийг нь баталсан байна. (Хавсралт №1)

Иймд аймаг, сумдын Засаг даргад хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд орон нутагт батлах шаардлагатай журам, үнэ тариф, хураамжийн хэмжээг аргачлалын дагуу бодит тоон мэдээлэлд үндэслэн тогтоож, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

3.2.2 Аймгийн төвийн Сүмбэр суманд хог хаягдлыг цэвэрлэх, тээвэрлэх, устгах, булшлах ажлыг “Тохижилт сүмбэр” ОНӨААТҮГ хариуцан гүйцэтгэж байна. Аймаг, сумын ЗДҮАХ, ЭЗНХҮЧ, 5 жилийн хөгжлийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт хог хаягдлын менежментийг сайжруулахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг шат дараалалтай шийдвэрлэснээр “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын техникийн хүчин чадал сайжирсан байна.

Хог хаягдлын чиглэлээр 2014-2021 онд “Тохижилт сүмбэр” ОНӨААТҮГ-т хийсэн хөрөнгө оруулалтын ажлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 7

(сая төгрөгөөр)

№	Хүлээн авсан техник, тоног төхөөрөмж	2014	2017		2019	2020	2021	Нийт	Хувиар
1	Хог хаягдал ачих машин	31.1			60.0	149.5	67.8	308.4	51.1%
2	Бичил цэвэрлэгээний машин						114.4	114.4	19.0%
3	Усалгаа, арчилгааны ус зөөвөрлөх автомашин		81.0					81.0	13.4%
4	Хогийн сав /Зөөврийн, үүрдэг, ангиалан ялгах/	35.9	12.1			31.9		79.9	13.2 %
5	Хогны машины засвар					20.0		20.0	3.3%
	Дүн	66.9	93.1		60.0	201.4	182.2	603.6	100.0%

(Эх сурвалж: Аймаг, сумын ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж)

Хүснэгтээс харахад: Хог хаягдлын чиглэлээр хийгдсэн хөрөнгө оруулалтын 83.5%-ийг автомашин худалдан авах, 13.2%-ийг хогийн саваар хангах арга хэмжээ эзэлж байна.

Тус байгууллага хүний нөөцийн дутагдалтай байдлаас шалтгаалан батлагдсан орон тоогоор бүрэн ажиллаагүй байна.

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ нь 2020, 2021 оны орон тоо, цалингийн санг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 8

(сая төгрөгөөр)

Он	Орон тоо			Цалин сан			Дундаж цалин хөлс		
	Төл	Гүйц	Зөрүү	Төл	Гүйц	Зөрүү	Төл	Гүйц	Зөрүү
2021	36	27	9	205.8	197.1	8.7	5.72	7.30	- 1.58
2020	36	26	10	216.1	204.9	11.2	6.00	7.88	- 1.88
Сарын дундаж цалин хөлс							0.5	0.63	- 0.14

Хүснэгтээс харахад: “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ ажиллагсдын дундаж цалин хөлс 2021 оны байдлаар сардаа 0.6 сая төгрөг байна. Тус байгууллагын жолооч, ачигч нар тус бүр 0.5 сая төгрөгийн үндсэн цалинтай бөгөөд 2020, 2021 онд 72.2-75.0% буюу 9-10 орон тоо дутуу ажилласан нь ажиллагсдын цалин хөлс нийтийн ахуй үйлчилгээний бусад салбараас хэт доогуур байгаа нь нөлөөлж байна.

Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ нь байгууллагын дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж мөрдөөгүй, хог хаягдлын тухай хуульд заасан гүйцэтгэлээр санхүүжих зарчмыг хэрэгжүүлдэггүй, ажиллагсдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2, 19.1.4, 19.1.5, 19.1.8-т заасныг зөрчсөн тул байгууллагын дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж мөрдөх, менежментийн төлөвлөгөөт шинэчлэл хийж ашигт ажиллагааг сайжруулах, хог хаягдлын тухай хуульд заасан гүйцэтгэлээр санхүүжих зарчимд шилжих, ажиллагсдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах зөвлөмжийг Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-т хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 114.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 6 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж, 4 албан шаардлага өгөв.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-1

1. Дунд хугацааны бодлогын баримт бичигт санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг бодитой төлөвлөөгүйгээс хэрэгжилт, үр дүнд сөрөг нөлөө үзүүлсээр байна.
2. Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж батлуулаагүйгээс дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт үндэсний хөтөлбөрийн уялдаа хангагдаагүй байна.
3. Арга хэмжээний хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй, шалгуур үзүүлэлтүүдийг хангаагүй арга хэмжээг бүрэн хэрэгжсэнээр үнэлж тайлагнасан байна.

Бүлэг-2

1. Санхүүгийн тооцоо судалгаа, шинжилгээнд үндэслэн төлөвлөлт хийхгүй байгаагаас хөтөлбөр, арга хэмжээ зорилтот түвшинд хүрч үр дүнтэй хэрэгжихгүй байна.
2. 2016-2020 онд зарцуулсан 462.4 сая төгрөгийн 67.7 хувь нь нэг удаагийн буюу урсгал зардлын шинжтэй арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Бүлэг-3

1. Төрийн байгууллага, албан тушаалтнууд хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд үр нөлөөтэй хамтран ажиллаагүй, Хог хаягдлын тухай хуульд заасан гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоо бүрдээгүй байна.
2. Хог хаягдлын үйлчилгээний хураамж болон зардлын нэгж тарифыг заавар аргачлалын дагуу бодитой тогтоодоггүйгээс хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжтой ажил үйлчилгээг төрийн захиргааны байгууллага өөрөө гүйцэтгэж байна.
3. Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ нь 2020, 2021 онд батлагдсан орон тооноос 72.2-75.0% буюу 9-10 дутуу ажилласан нь ажиллагсдын цалин хөлс нийтийн ахуй үйлчилгээний бусад салбараас хэт доогуур байгаатай холбоотой байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд:

1. “Хог хаягдлын тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж, эрхзүйн баримт бичгүүдийг заавар аргачлалын дагуу баталж, мөрдүүлэх, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг батлах, нэн тэргүүний шаардлагатай төвлөрсөн хогийн цэгт цахилгаан татах, авто пүү байршуулах, ландфиллын стандартыг хангах төсөв санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх

Аймаг, сумын Засаг даргад:

1. Бодлогын баримт бичигт тусгаж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг бодитой төлөвлөх
2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, төвлөрсөн хогийн цэгт цахилгаан татах, авто пүү байршуулах, ландфиллын стандартыг хангах, түүнд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөж батлуулах, хэрэгжилтийг хангах
3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж, баримт нотолгоонд үндэслэн гаргах

Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-ын даргад:

1. Байгууллагын дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж мөрдөх, менежментийн төлөвлөгөөт шинэчлэл хийж ашигт ажиллагааг сайжруулах, хог хаягдлын тухай хуульд заасан гүйцэтгэлээр санхүүжих зарчимд шилжих, ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлж ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Найрамдал хотхон, 3 дугаар баг,
Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42015
Утас: 7054 3063, Цахим шуудан: baigal@gs.gov.mn

2022.10.28 № 261

танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Хог хаягдлын менежмент түүний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж саналыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт...хуудастай.

ДАРГА  Д.МӨНХ-ЭРДЭНЭ



На Б. Дарханбаатар
Саналтай танилцаж
тайланг хүргэж
баталгаажуулав


x/28

4222030097

Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын 2022 оны 10-р сарын 28-
ний өдрийн 81 тоот албан бичгийн
1... хавсралт

Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгуулах санал

1.	Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал	Төвлөрсөн хогийн цэгрүү цахилгааны шугам татах, авто пүү байршуулах, ландфиллыг стандартын дагуу хийх боломж нөхцөлийг бүрдүүлэх хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх
2.	Шалгагдагч байгууллагын санал	Сумдууд Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөгөө бүрэн хийж түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө зардлын төлөвлөлтөө хийх, төсвөөс бүрэн хараат байдлыг бууруулах зайлшгүй шаардлагатай талаар зөвлөмж хүргүүлэх
3.		

Алдаа зөрчлийн бүртгэлийн бүртгэлийн тайлбарт

1.	Зөвлөмжийн санал -4 “67.7 хувь нь нэг удаагийн, урсгал зардлын шинжтэй арга хэмжээг санхүүжүүлсэн” гэжээ	Туурь балгас цэвэрлэх, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, сургалт, олон нийтийн нөлөөллийн арга хэмжээнүүд нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад зайлшгүй хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ тул үр дүнгүй гэж үзэлгүй эргэж нягтлахыг хүсье
----	---	--

Боловсруулсан мэргэжилтэн

Н.Маралгуя

Хянасан дарга

Д.Мөнх-эрдэнэ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас/Факс: (976) 7054 3005,
И-мэйл: zdtg.gsa@gmail.com, Вэбсайт: www.govisumber.gov.mn

2022.11.01 № А/1409

танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Монгол улсын Их хурлын төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хийгдсэн “Хог хаягдлын менежментийн хэрэгжилт үр дүнг үнэлэх” ажлын гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлантай холбоотой санал байхгүй болно.



Г.БАТЗАМ

Анх Б.Дархандатай
Тайланг тушаал
Тайланг зурвал
Батаалсан үүсвэр

4286000547
Хууль
21/01

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Байгаль орчин аялал жуулчлалаас газраас ирүүлсэн аудитын тайланд тусгуулах саналыг хянаж үзээд утга агуулгын хувьд дараах байдлаар өөрчлөлт оруулав. Үүнд:

Аудитын зөвлөмж

Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд:

1. “Хог хаягдлын тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж, эрхзүйн баримт бичгүүдийг заавар аргачлалын дагуу баталж, мөрдүүлэх” гэсэн зөвлөмжийг “Хог хаягдлын тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж, эрхзүйн баримт бичгүүдийг заавар аргачлалын дагуу баталж, мөрдүүлэх, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг батлах, нэн тэргүүний шаардлагатай төвлөрсөн хогийн цэгт цахилгаан татах, авто пүү байршуулах, ландфиллын стандартыг хангах төсөв санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх”

Аймаг, сумын Засаг даргад:

2. “Хог хаягдлын тухай хуульд заасан эрхзүйн баримт бичгүүдийг заавар аргачлалын дагуу боловсруулж, аймаг сумын ИТХ-аар батлуулж, мөрдүүлэх, Үндэсний хэмжээнд хэрэгжих хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах” гэсэн зөвлөмжийг “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, төвлөрсөн хогийн цэгт цахилгаан татах, авто пүү байршуулах, ландфиллын стандартыг хангах, түүнд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөж батлуулах, хэрэгжилтийг хангах” гэж тус тус өөрчлөлт орууллаа.

ХАВСРАЛТ

Хавсралт 1

Хог хаягдлын тухай хуулиар аймаг, сумын ИТХ, Засаг даргын шийдвэрээр хэрэгжих эрх зүйн баримт бичгийн жагсаалт

№	Огноо	Агуулга	Хуулийн заалт	Шийдвэрийн дугаар	Тайлбар
1	2020.05.22	Аймгийн хэмжээнд "Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журам"	9.3.12.	АЗД №А/162	Батлагдсан
2		Энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифыг батлах	9.2.1.	Сумын ИТХ	Батлагдаагүй
3	2022.07.07-2019.11.28	Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг шинэчлэн батлах тогтоох тухай	9.2.2.	Сүмбэр сумын ИТХХ, ШГСИТ Х №03, 88	Батлагдсан боловч аргачлалд нийцээгүй
4		Хог хаягдлын менежментийг сайжруулах орон нутгийн хөтөлбөрийг баталж, биелэлтэд хяналт тавих	9.1.2.	АИТХ	Батлагдаагүй
5		Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг баталж, мөрдүүлэх	9.1.3.	АИТХ	Батлагдаагүй
6	2018.12.05	Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифыг батлах	9.1.4.	АИТХ №08	Батлагдсан
7		"Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, экспортлох үйл ажиллагаа эрхэлдэг болон байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид эдийн засгийн урамшуулал олгох журам"	9.1.5.	АИТХ	Батлагдаагүй
8		"Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам"	9.3.2. 9.3.3	АЗД	Батлагдаагүй
9	2021.04.23 2021.05.10	Нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал, цас, мөсийг хариуцан цэвэрлэх 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын хилийн заагийг тогтоох	9.4.12.	Баянтал, ШГС, Сүмбэр А/41, А/59	Батлагдсан